



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/11

Шивээговь сум

Г Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Тавнан овогт Мягмарсүрэнгийн Номинзул /ЕЙ92033019/ нь Шивээговь сумын 2-р баг, Хаялга усны баруун талд байрлах "Гэр бүлийн хэрэгцээ"-ний зориулалттай 500 м2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигин овогтой Баярсайханы Лүнгэрэгжанцан /ЗН93030311/-д Шивээговь сумын 2-р баг, Хаялга усны баруун талд байрлах 500 м2 газрыг "Гэр бүлийн хэрэгцээ"-ний зориулалтаар өмнө нь авсан иргэний үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Б.Лүнгэрэгжанцан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Б.Лүнгэрэгжанцантай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/178 дугаар захирамжийн хавсралтын 15 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.СУГАРМАА